

Төсөл

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ ТҮР ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүүхдийг бие махбод, сэтгэл зүйн дарамт, заналхийлэл, ялгаварлан гадуурхалт, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зүй бус бусад нөлөөлөл болон амь нас, эрүүл мэндэд аюул учруулах гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй газарт түр байрлуулах, түр хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Монгол Улсын олон улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, болон бусад олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“**Хүүхэд**” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаар;

1.3.2.“**Хүүхдийн эсрэг хүчирхийлэл**” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.8-д зааснаар;

1.3.3.“**Түр хамгаалах байр**”гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5-д зааснаар;

1.3.4.“**Нэг цэгийн үйлчилгээний төв**” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.3-т зааснаар;

1.3.5.“**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг**” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4-т зааснаар.

1.4.Хүүхдийг аюулгүй газар түр байрлуулах үйл ажиллагаанаас үүсэх эрх зүй, эдийн засгийн үр дагаврыг эрх бүхий байгууллага бүрэн хариуцаж зохион байгуулна.

Хоёр.Хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл хамгаалах байранд хүргэх

2.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн хүүхэд долоо, түүнээс дээш настай, аюулын эрсдэлийн зэрэг бага бол эцэг эх, харгалзан дэмжигч, өөрийнх нь саналыг харгалзан, хүүхэд өөрийн хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын эрсдэлийн зэрэг дунд, өндөр бол эцэг, эх, асран хамгаалагчийн саналыг харгалзахгүйгээр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэлх хугацаанд түр хамгаалан байрлуулна.

2.2.Хүчирхийлэлд өртсөн хүүхэд долоогоос доош настай бол гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал эрхэлсэн байгууллагаас тогтоосон итгэмжит төлөөлөгчийн хамт аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр хамгаалан байрлуулна.

2.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4-д тус тус заасны дагуу хүүхдийг түр хамгаалалтанд авна.

2.4. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах байранд хавсралтад заасан маягт №1,2-ын дагуу бүртгэж, хүлээн авч, шилжүүлэн өгнө.

2.5.Хүүхдийг түр байрлуулах хамгаалалтын байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартаар тавигдах шаардлагыг хангасан байна.

2.6.Түр хамгаалах байр нь хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хүн, гэр бүлийн хүмүүс байрлах тусгай өрөөнүүдтэй байна.

2.7.Түр хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ба зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

2.8.Хүчирхийллийн улмаас хүүхдийн бие махбодод гэмтэл бэртэл учирсан, хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төвд хүргэнэ.

2.9. Төв, орон нутгаас аюулын зэргийн үнэлгээ өндөр хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, түр хамгаалан байрлуулах, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тухайн орон нутгийн хамтарсан багийн шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ.

2.10. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрласан хүүхдийн талаарх мэдээллийн санг үүсгэж, хагас, бүтэн жилээр Цагдаагийн төв байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ

3.1. Түр хамгаалах байранд хамгаалалтад авагдсан хүүхдэд дараах үйлчилгээг үзүүлнэ.

3.1.1. Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ;

3.1.2. Сэтгэл зүйн үйлчилгээ;

3.1.3. Нийгмийн халамжийн үйлчилгээ;

3.1.4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ;

3.1.5. Эрх зүйн туслалцаа.

3.2. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээнд хамгаалалтад авагдсан хохирогч хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах арга хэмжээ авна.

Дөрөв.Хүүхдийг асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх

4.1.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд долоо, түүнээс дээш настай бол хүүхдийг асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэхдээ түүний саналыг харгалзана.

4.2.Хүүхдийг асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх ажлыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан харьяа сум, баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.

Тав. Хүүхдийг хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх

5.1.Хүүхдийг эцэг эх, төрөл садангийн болон бусад хүн, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх бол түүнд эрх, үүргийг сануулж, бичгээр баталгаажуулна.

5.2.Хохирогч хүүхэд долоо, түүнээс дээш настай бол хамгаалах боломжтой хүн, гэр бүлийг сонгохдоо түүний саналыг харгалзана.

Зургаа.Бусад

6.1.Хамгаалах байрны ажилтан ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөн /халагдсан/-ий дараа хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаар аливаа төрлийн мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.

6.2. Хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагын ажилтан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.

6.3. Хүүхдийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

---oOo---

**ХАМГААЛАХ БАЙРАНД ХҮҮХЭД ХҮЛЭЭЖ АВСАН
БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

1. Үйлчлүүлэгчийн код:
2. Ирсэн өдөр:
3. Гарсан өдөр:

4. Хүргэж ирсэн болон зуучилсан байгууллага, иргэний мэдээлэл:

.....
.....

Утас:

д/д	Товч анкет	
1.	Овог, нэр	
2.	Нас, хүйс, регистрийн дугаар	
3.	Гэрийн хаяг, утасны дугаар	
4.	Хүүхдийн эрүүл мэндийн ерөнхий байдал	
5.	Сургууль, цэцэрлэгт хамрагдсан эсэх	
6.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан байдал	

7. Үйлчлүүлэгчийн ам бүл

№	Гэр бүлийн гишүүдийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			

8. Үйлчлүүлэгчид туслах ойр орчны хүмүүсийн мэдээлэл

№	Гэр бүлийн гишүүдийн овог нэр	Хэн болох	Эрхэлдэг ажил	Гэрийн хаяг	Утас
1.					
2.					
3.					
4.					

9. Түр хамгаалах байранд ирж байсан эсэх

		1. Тийм <input type="checkbox"/>		2.Үгүй <input type="checkbox"/>	
Хэдэн удаа ирсэн	Өмнө ирсэн огноо	Хэнтэй хамт ирсэн	Ямар асуудлаар ирсэн	Ямар үйлчилгээнд хамрагдсан	
	1.				
	2.				
	3.				
	4.				
	5.				

10. Бусад байгууллагын хамгаалах байранд очиж байсан эсэх.

		1. Тийм <input type="checkbox"/>		2.Үгүй <input type="checkbox"/>	
Хэдэн удаа ирсэн	Өмнө ирсэн огноо	Хэнтэй хамт ирсэн	Ямар асуудлаар ирсэн	Ямар үйлчилгээнд хамрагдсан	
	1.				
	2.				
	3.				
	4.				
	5.				

11. Хүчирхийлэгчийн овог нэр, нас, хүйс

.....

.....

12. Хүчирхийллийн илрэл:

.....

.....

13. Нэн тэргүүнд ямар хэрэгцээг нь шийдвэрлэх шаардлагатай байна вэ?

1/.....

.....

2/.....

.....

ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ДУУСГАХ,
БУСАД БАЙГУУЛЛАГАД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ МАЯГТ

20...оны...сарын.....өдөр

Үйлчлүүлэгчийн тухай мэдээлэл	
1. Үйлчлүүлэгчийн код.....	5. Ирсэн өдөр.....
2. Үйлчлүүлэгчийн овог:.....	6. Гарсан өдөр.....
3. Үйлчлүүлэгчийн нэр:.....	7. Гэрийн хаяг.....
4. Регистрийн дугаар:.....	8. Утасны дугаар.....
	9. Иргэний харьяалал.....

10. Үйлчлүүлэгчийн одоогийн нөхцөл байдал /Биед ил харагдах гэмтэл, өвчин зовиур, сэтгэл санааны байдал/

.....

.....

.....

.....

А.Түр хамгаалах байрнаас үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээ

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээнд хамрагдсан хугацаа
1.	<input type="checkbox"/> Аюулгүй байдлыг нь хамгаалах, түр байрлуулах	
2.	<input type="checkbox"/> Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	
3.	<input type="checkbox"/> Нотлох бичиг баримт бүрдүүлэх	
4.	<input type="checkbox"/> Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	
5.	<input type="checkbox"/> Өглөө, өдөр, оройн хоол хүнсээр хангах	
6.	<input type="checkbox"/> Анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	
7.	<input type="checkbox"/> Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	
8.	<input type="checkbox"/> Чиг сэтгэлийн бүлгийн ярилцлагад оролцох	
9.	<input type="checkbox"/> Хуулийн зөвлөгөө өгөх эрх зүйн туслалцаа үзүүлэх	
10.	<input type="checkbox"/> Мэдээ мэдээллээр хангах	
11.	<input type="checkbox"/> Бусад.....	

Б. Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэсэн байдал

.....

.....

.....

.....

В.хүлээж авсан

Тэмдэглэл:

.....

.....

.....

Г. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд цаашид яаж анхаарч ажиллах талаарх тэмдэглэл

Нийгмийн ажилтан:.....

.....

.....

.....

Хэсгийн байцаагч:.....

.....

.....

.....

.....

Бусад:.....

.....

.....

.....

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТАН / /

ХҮЛЭЭН АВСАН: / /